






# Төрийн байгууллагуудаас авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэх аргачлал, анхаарах асуудал



## Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ХЭЛТЭС

# Зорилго

Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааны үр дүнд нь цогц байдлаар үнэлгээ өгөх

# Ач холбогдс

- Төрийн байгууллага, түүний удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санал санаачилга, хүчин чармайлтыг дэмжих;
- Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, хяналтын бодитой тогтолцоо бий болгох;
- Төрийн албан хаагчдын шударга байдлын түвшинг нэмэгдүүлэх;
- Төрийн байгууллагаас хэрэгжүүлж буй үлгэр жишээ, тэргүүн туршлагыг илрүүлэх, түгээн дэлгэрүүлэх.

# Эрх зүйн үндэслэл

- Авлигын эсрэг хууль /18.1.1, 18.4.4/;
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль /28.1.2/.

# Зорилго

Авлигын эсрэг хууль  
тогтоомжийн хэрэгжилтийг  
хангах, үйл ажиллагааны үр  
дүнд нь цогц байдлаар  
үнэлгээ өгөх

# Ач холбогдол

- Төрийн байгууллага, түүний удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санал санаачилга, хүчин чармайлтыг дэмжих;
- Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, хяналтын бодитой тогтолцоо бий болгох;
- Төрийн албан хаагчдын шударга байдлын түвшинг нэмэгдүүлэх;
- Төрийн байгууллагаас хэрэгжүүлж буй үлгэр жишээ, тэргүүн туршлагыг илрүүлэх, түгээн дэлгэрүүлэх.

# Эрх зүйн үндэслэл

- Авлигын эсрэг хууль /18.1.1, 18.4.4/;
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль /28.1.2/.

# **Авлигын эсрэг үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явц**

Авлигын эсрэг үйл  
ажиллагааны төлөвлөгөө  
боловсруулан батлах,  
Авлигатай тэмцэх газарт  
хүргүүлэх  
1-2 сард

Авлигын эсрэг үйл  
ажиллагааны  
төлөвлөгөөг  
хэрэгжүүлэх  
2-11 сард

Төлөвлөгөөний  
гүйцэтгэлийн тайланг  
нотлох баримтын хамт  
Авлигатай тэмцэх  
газарт хүргүүлэх  
11 сарын 15

Үр дүнг мэдээлэх  
12 сарын 09

# *Үнэлгээний агуулга*

- Хуулиар хүүлээсэн үүргийн биелэлт; 0-70 оноо
- Авлигатай тэмцэх санал, санаачилга 0-30 оноо

**/2 үндсэн, 22 дэд хэсэгтэй/**

# *Арга зүй*

- Төрийн байгууллагын тухайн жил хийхээр төлөвлөсөн ажлын төлөвлөгөө;
- Гүйцэтгэлийн тайлан;
- Нотлох баримтад шинжилгээ хийнэ.



# Үнэлгээнд хамрагдах байгууллагууд

- Улсын Их Хурлаас байгууллагддаг байгууллага 7;
- Яам 16;
- Засгийн газрын Агентлаг 28;
- Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар 22;
- Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага 40;

+Нийслэлийн 9 дүүрэг,

+“Хамтдаа” төсөл хэрэгжиж буй 4 агентлаг

+Санал орон нутгийн захиргааны байгууллагууд үнэлгээнд хамрагдах

## *Гүйцэтгэгч*

**Иргэний нийгмийн байгууллагын  
төлөөлөл бүхий шинжээчийн баг**

*Авлигатай тэмцэх газрын Урьдчилан  
сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга,  
шинжээчдийн багийн ахлагчтай ажил  
гүйцэтгэх гэрээг байгуулж ажиллана!*

# Оролцоо

## Авлигатай тэмцэх газар

Төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх явцад төрийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

Төлөвлөгөө, түүний гүйцэтгэлийн тайланг хүлээн авах, хуулбарыг Шинжээчдийн багт хүргүүлэх;

Нотлох баримтыг цуглуулах, төрийн байгууллагын холбогдох албан тушаалтныг Шинжээчтэй багтай холбож өгөх;

Шаардлагатай мэдээллийг шинжээчид гаргаж өгөх бөгөөд тус багийн үйл ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

Сайн туршлагыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх;

Үнэлгээнд хамрагдсан байгууллагуудад үнэлгээний дүнг хүргүүлэх;

Үнэлгээний дүн, тайлан мэдээг холбогдох байгууллага /ЗГХЭГ, УИХ-ын Тамгын газар, Төрийн өмчийн хороо г.м/-д хүргүүлэх, олон нийтэд мэдээлэх.

## Үнэлгээнд хамрагдаж буй байгууллага

Авлигын эсрэг үйл ажиллагааг төлөвлөх, төлөвлөгөө, гүйцэтгэлийн тайланг тогтсон хугацаанд Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх;

Шаардлагатай нотлох баримтыг гаргаж өгөх;

Төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнахтай холбоотой асуудлаар Авлигатай тэмцэх газраас мэргэжил, арга зүйн зөвлөгөө авах.

## Шинжээчдийн баг

Үнэлгээний тайланг тогтсон хугацаанд гаргаж, Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх;

Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажиллах. Шинжээчдийн багийн гүйцэтгэх ажлыг “Ажил гүйцэтгэх гэрээ”-нд тодорхой тусгана.


**Хуулиар хүлээсэн үүргийн биелэлт 0-70 оноо**

**Авлигатай тэмцэх санал, санаачилга 0-30 оноо**

**Авлигатай тэмцэх санал, санаачилга хэсгийн байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын хүрээнд илрүүлсэн авлигын зөрчил, авсан арга хэмжээ, түүний үр дүн, санаачилгыг харгалзан 10 хүртэл нэмэх оноо өгөх бөгөөд бусад байгууллага, иргэдийн гомдлоор илэрсэн зөрчил, авсан арга хэмжээ, Авлигатай тэмцэх газрын шалгалтаар илэрсэн авлигын гэмт хэрэг ба бусад зөрчлийг харгалзан тус тус 5 хүртэл хасах оноо өгч үнэлнэ.**

**Авлигатай тэмцэх газар нь аргачлалын “Долоо”-ийн 7.3 болон бусад Авлигатай тэмцэх газраас шалтгаалан үнэлэх ажлын үнэлгээг Шинжээчдийн багт хүргүүлсэн байна.**

# Тайлагналт, үр дүнг мэдээлэл



*Ололт, амжилт*



***Тайлан***

*Хүрсэн үр дүн*



*Хүндрэл, бэрхшээл*



- Үнэлгээтэй холбоотой саналаа Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх нь нээлттэй;
- Төрийн байгууллагуудын болон Шинжээчдийн багийн саналыг үндэслэн авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлэх аргачлал, шалгуурт өөрчлөлт оруулж болно;
- Өөрчлөлт орсон даруй төрийн байгууллагуудад мэдэгдэнэ.

# 2013 оны үнэлгээ

УИХ-ын 7 байгууллага	51%
Яамд 16	53,5%
Засгийн газрын 27 агентлаг	55%
Нийслэл, 21 аймгийн ЗДТГ	51,3%
Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 48 хуулийн этгээд	29,3%
<b>Нийт 120</b>	<b>48,3%</b>



# Үр дүн

- Төрийн байгууллагуудыг өмнөх онуудаас бодит үр дүнтэй аргаар үнэлж чадсан;
- Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл бүхий шинжээчийн баг;
- Төрийн байгууллагуудын идэвх чармайлт нэмэгдсэн;
- Нэг бүрчилсэн, тусгайлсан, нийтлэг гэх мэт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжууд бүрдсэн. Жишээ нь бид муу үнэлгээ авсан 6 аймагт очиж ажил сайжруулах, арга зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор ажиллаж байна. Эрчим хүчний яам, Гадаад хэргийн яамтай хамтарсан ажлын хэсэг байгуулж авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг нь боловсруулж өгсөн.
- Харж чадаагүй байсан олон зүйлээ харж чадсан. Жишээ нь Авлига, Ашиг сонирхлын зөрчлийг үүсгэж буй шалтгаан нөхцөлүүдийг олж харсан. Цаашид бид шалтаан нөхцөлийг таслан зогсоох арга хэмжээ авч ажиллах бололцоо бүрдсэн.

# Анхаарал асуудлууд

Улсын Их Хуралд хэлэлцэгдэх хууль, шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслүүдэд иргэд, олон нийт сонирхогч бүлгүүдийн саналаа өгөх болон саналыг нь хүлээж авах механизмыг бүрдүүлэх;

Төсөв санхүүгийн ил тод байдлыг хангаж ажиллах, тэдгээрийг хуульд заасан хугацаанд цахим хуудсанд, мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах;

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллах

Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээний талаарх мэдээллийг тухай бүр ил тод, нээлттэй болгох;

Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт хангах, уг асуудлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг санхүүжүүлэх;

Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авч ажилласан хэдий ч хийсэн хяналт шалгалтынхаа үр дүнг олон нийтэд хэрхэн мэдээлсэн нь тодорхой бус;

Чиг үүргийн дагуу олгосон зөвшөөрөл, зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааны талаарх мэдээллийг ил тод нээлттэй болгох;

Зөрчлийн талаарх бүртгэл хөтлөх, зөрчлийг хянан шийдвэрлэсэн байдал, зөрчил үүсэн буюу үүсч болзошгүй тохиолдолд авсан урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн байдал /Зөвлөмж/, зөрчил хүлээлгэсэн тохиолдолд хуульд заасан хариуцлагыг хүлээлгэсэн талаарх мэдээлэл байдаггүй;

ЭБАТ-ын ажлын хариуцлагыг нэмэгдүүлэх, идэвхи санаачлагатай болгох;

Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах, эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээг гүйцэтгэх албан тушаалтан, ажилтны үйл ажиллагааг хянах нөхцөл боломжийг бүрдүүлэх;

Давхар ажил эрхлэлттэй холбогдсон хязгаарлалтыг хэрэгжүүлэх журам, түүний биелэлтийн талаарх мэдээлэл байхгүй .

Албан хаагч нэг бүрийн хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг нээлттэй болгож байх.

# АНХААРАХ АСУУДЛУУД:

Улсын Их Хуралд хэлэлцэгдэх хууль, шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслүүдэд иргэд, олон нийт, сонирхогч бүлгүүдийн саналаа өгөх болон саналыг нь хүлээж авах механизмыг бүрдүүлэх;

Төсөв санхүүгийн ил тод байдлыг хангаж ажиллах, тэдгээрийг хуульд заасан хугацаанд цахим хуудсандаа, мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах;

# АНХААРАХ АСУУДЛУУД:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллах

Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээний талаарх мэдээллийг тухай бүр ил тод, нээлттэй болгох;

# АНХААРАХ АСУУДЛУУД:

Авлигын эсрэг үйл  
ажиллагааны төлөвлөгөөний  
хэрэгжилт хангах, уг  
асуудлыг хэрэгжүүлэхэд  
шаардлагатай зардлыг  
санхүүжүүлэх;

Дотоод хяналт шалгалтын  
төлөвлөгөө, түүний мөрөөр  
холбогдох арга хэмжээг авч  
ажилласан хэдий ч хийсэн  
хяналт шалгалтынхаа үр  
дүнг олон нийтэд хэрхэн  
мэдээлсэн нь тодорхой бус;

# АНХААРАХ АСУУДЛУУД:

Чиг үүргийн дагуу олгосон зөвшөөрөл, зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааны талаарх мэдээллийг ил тод нээлттэй болгох;

Зөрчлийн талаарх бүртгэл хөтлөх, зөрчлийг хянан шийдвэрлэсэн байдал, зөрчил үүсэн буюу үүсч болзошгүй тохиолдолд авсан урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн байдал /Зөвлөмж/, зөрчил хүлээлгэсэн тохиолдолд хуульд заасан хариуцлагыг хүлээлгэсэн талаарх мэдээлэл байдаггүй;

# АНХААРАХ АСУУДЛУУД:

**ЭБАТ-ын ажлын  
хариуцлагыг  
нэмэгдүүлэх, идэвхи  
санаачлагатай болгох;**

**Авлигад өртөх эрсдэлтэй ажил,  
албан тушаал, үйлчилгээний  
жагсаалтыг гаргах, эрсдэлтэй  
ажил, албан тушаал, үйлчилгээг  
гүйцэтгэх албан тушаалтан,  
ажилтны үйл ажиллагааг хянах  
нөхцөл боломжийг бүрдүүлэх;**

# АНХААРАХ АСУУДЛУУД:

Давхар ажил эрхлэлттэй холбогдсон хязгаарлалтыг хэрэгжүүлэх журам, түүний биелэлтийн талаарх мэдээлэл байхгүй .

Албан хаагч нэг бүрийн хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг нээлттэй болгож байх.



# Шинжээчдийн өгсөн санал, дүгнэлт

- Төрийн байгууллагууд хамгийн түрүүн цахим хуудасныхаа агуулгыг хуульд заасан шардлагад нийцүүлэн, бүтэц загварын хувьд иргэдэд ойлгомжтой, хэрэглэхэд хялбар, хүртээмжтэй, өндөр хурдтай болгох;
- Авлигын эсрэг үйл ажиллагааны жилийн ажлын төлөвлөгөө боловсруулахдаа хуулиар тогтоосон агуулгын шаардлагад нийцүүлэн, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасан хугацаанд, мэдээлэл оруулах хариуцах ажилтныг тодорхойлж, график тогтоон байнга мөрдөж, хэрэгжүүлсэн ажлаа тухайн үед нь нотлох баримтаар баталгаажуулж хэвших;
- Жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор АТГ-т төлөвлөгөөний тайланг ирүүлэхдээ төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийг нэгбүрчлэн тусгаж, тухайн ажил, арга хэмжээг хэрэгжүүлсэн нотлох баримтыг бүрэн хавсаргах нь зүйтэй;
- Шалгуур үзүүлэлтэд тусгагдсан тусгай зөвшөөрөл, бүртгэл, уралдаант шалгаруулалт, концесс зэрэг зарим үзүүлэлтүүд тухайн байгууллагын хувьд хамааралгүй бол тэр тухай гүйцэтгэлийн тайланд тодорхой тусгаж ирүүлэх.

***Анхаарал  
хандуулсанд  
баярлалаа***